



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/502


Мөрөн сум

Дипломат, албан паспорт
олгох хүсэлт уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ын 2.2.2, 3.7.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг дарга Д.Идэрмөнх нь 2023 оны 10 дугаар сард Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Янпён тосгонд зочилж Нийгмийн халамжийн судалгааны нийгэмлэгтэй хамтран ажиллах, хоёр талын нийгмийн хамгааллын бодлого, халамжийн үйлчилгээний чиглэлээр харилцан мэдээлэл солилцохоор төлөвлөж байгаа тул албан паспорт олгуулах хүсэлтийг Гадаад харилцааны яаманд уламжилсугай.
2. Гадаад улсад албан томилолтоор ажиллахдаа Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах журам”, Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ын хэрэгжилтийг тус тус хангахыг Мөрөн сумын Засаг дарга (Д.Идэрмөнх)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ